

Түүнчлэн хоригдогсод нь хорих анги, баривчлах цагдан хорих байранд бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж байгаа, мөн хорих ангиас харуул хамгаалалтын сул байдал эсхүл тухайн анги, албаны үйл ажиллагааны онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер техникийн хэрэгсэлийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдэгдсээр байна. Энэ нь хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах зүй тогтлыг онолын үүднээс шат дараатай судлан, практик ач холбогдлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна

**Б.МӨНХБААТАР**

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДАХЬ УГСААТНЫ СЭТГЭЛ ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Монгол хэлний тайлбар толинд:

Угсаатан (ᠤᠭᠰᠠᠭᠠᠲᠠᠨ) — нэгэн төрлийн хэлтэй ард түмэн. Үндэстнээс өргөн арьстнаас явцуу хэмжээний ард түмний хуваарь.

XVIII зуунд Францын соён гэгээрүүлэгчид “ард түмний оюун сэтгэл” гэдэг ухагдахууныг юуны өмнө газар зүйн хүчин зүйлс, цаг уур, түүнчлэн шашин, зан заншил, өнгөрсөн үеийн түүх, үлгэр домог зэрэг ард түмний өвөрмөц онцлогийг тодорхойлж чадна гэж тайлбарласан байдаг. Аливаа үндэстний сэтгэл зүйн байдал нь түрүүчийн үе удмаас өвлөгдөж ирсэн амьдралын ёс заншил, уламжлалын үр дүнд бүрэлдэн тогтсон сэтгэхүйн хэв маяг зан үйлд илэрдэг байна. Энэ нь түүхэн хөгжлийн бүрэлдэхүүн бөгөөд нэг үе удмаас нөгөө үе удамд тайван алгуур тогтвортойгоор дамжин бий болдог гэж үздэг.

Үндэсний шинж байдал гэдэг ухагдахууныг эхэн үед ард түмний аж амьдралыг илэрхийлэх зорилготой тодотгодог байсан хэдий ч өнөөгийн нийгэмд үндэстний шинж байдлыг судлахдаа тэдний ааш араншин, хүний

хувийн шинж төрх, үнэлэмж, эрх мэдэл, хөдөлмөрт хандах хандлага зэргийг тодотгон авч үзэх болсон. Гэсэн хэдий ч үндэсний шинж байдал гэдэг нэрийн дор нэг ард түмний нөгөөгөөс ялгагдах сэтгэл зүйн аливаа нэг онцлогийг ойлгодог.

Үндэстний сэтгэл зүйн онцлог нь хүмүүсийн үйл ажиллагааны хэлбэрт үндэсний шинж чанарт, ёс суртахууны өвөрмөц хэлбэрт хүртэл нөлөөлж байдаг гэж ойлгож болох юм. Үндэсний зан төрх гэдэг нь аливаа нэг үндэстэнд бий болж тогтсон сэтгэл зүйн тогтвортой байдал ба нийгэм ахуйн орчинд, хүрээлэн буй ертөнцөд, хөдөлмөртөө, өөрийн болон бусад үндэстэнд хандах хандлагад илэрдэг зуршил болсон зан ааш, нийтлэг үйлдлийг тодорхойлогч юм.

Энэ нь алив нэгэн угсаатны эв нэгдэл, бүрэн бүтэн байдлыг хамгаалахад үйлчлэгч сэдэл учир шалтгааныг тусгагч сэтгэл зүйн ба нийгмийн үзэгдэл юм. Үндэсний сонирхол, чиг хандлага нь хүмүүсийн зан үйл болон үйл ажиллагааг хөдөлгөгч чухал хүч нь гэж тодотгож болно.

Аливаа үндэстэн угсаатан оршин буй газар орон, цаг агаар, хэл заншил зэрэг ялгаатай байдгийн улмаас сэтгэл зүйн өвөрмөц хэв шинж бүрэлдэн тогтож байдаг нь мэдээж. Угсаатны сэтгэл судлал буюу ард түмний тухай шинжлэх ухаан нь оюун санааны хөгжлийн ерөнхий хуулийг тайлбарлах үүрэгтэй, харин ард түмний тус тусын сэтгэцийн шинжийг сэтгэл судлалд харилцан хамааралтай угсаатны зүйг тайлбарлах ёстой гэж зарим эрдэмтэд тодорхойлсон байдаг. Сэтгэл зүйн хэв маяг нь хүмүүсийн харилцаа, амьдрал, үйл ажиллагааны өвөрмөц үйл хэлбэрт

хадгалагдан илрэх *угсаатны* зан төрх, ухамсар, мэдрэмж, дадал зуршил, уламжлалын өвөрмөц байдлаар оршин тогтносоор байдаг байна.

Угсаатны шинж байдал гэдэг нь түүний төлөөлөгч тус бүрийн зан байдлын нийлбэр биш, харин олон тооны хувь хүмүүст янз бүрийн хэмжээгээр, төрөл бүрээр хослон байдаг тэрхүү нийтлэг чанрыг тодорхойлохдоо "Ард түмний шинж байдлыг ойлгохын тулд юуны өмнө түүний түүх, нийгмийн байгуулал ба соёлыг судлах хэрэгтэй, энд хувь хүнийг судлах сэтгэл зүйн арга хангалттай биш" гэж үздэг.

Бие хүнийг судлахдаа орон нутгийн үзэл баримтлалаар ангилан судлахын давуу тал нь- тэдгээр соёлын төлөөлөгчдийг өөрөө өөрсдийгөө ойлгох боломжоор хангаж өгдөг боловч, хувийн ба соёлын ялгааны цаана хүний сэтгэцийн тал бүрийн нийтлэгийг олохыг эрмэлздэггүй дутагдалтай талтай. Иймд бие хүний сэтгэл зүйг судлахдаа шинжлэх ухааны европ уламжлалыг харгалзах, хэрэглэхээс татгалзах нь нэг талаас зүйтэй гэж үзэж болох юм.

Монгол үндэстний хувьд түүний бүрдэл хэсэг гэж ойлгож болох угсаатны хувьд ч гэсэн хэд хэдэн зуунаар, хэдэн арванаар, тэр ч байтугай өчүүхэн богино хугацаагаар тогтон төлөвшсөн сэтгэл зүйн олон шинжүүд бий. Нийгмийн бусад бүлгүүдтэй өөрийн бүлгийг харьцуулсны үндсэн дээр нийгмийн болон угсаатны адилсалт төлөвшиж байдаг бөгөөд аливаа юмс түүний дотроос угсаатны шинж төрх ч зөрчил, тухайн тохиолдолд адилсалт, ялгаа хэмээх эсрэг тэсрэг талын хоорондох зөрчлийн зүй тогтолтой байдаг нь угсаатны адил төс бол өөрийгөө угсаатны нэг бүлгтэй ижилсүүлж нөгөөгөөс ялгаж буй ойлголт юм.

Үндэстэн угсаатан хоорондын сөргөлдөөнүүд янз бүрийн учир шалтгааны холбоотойгоор үүсдэг болохыг түүхэн эх сурвалжаас олж харж болхоос гадна өнөөгийн Монголын нийгмийн нэгээхэн далд хэлбэрийн үзэгдэл болсоныг мөн тодотгож болно. Гэтэл өнөөгийн Хорих ял эдлүүлэх ажиллагаанд үндэстэн, угсаатны хоорондын харилцааны онцлогийг харгалзсан ойлголт, зохицуулалт байдаггүй бөгөөд угсаатны сэтгэл зүйн онцлог, адилсалт ялгаа харилцан хамаарал сөрөг хандлага нь өнөөгийн хорих байгууллагын практикт тулгардаг гэмт хэрэг, зөрчил сөрөг үр дагварын үндэстэй холбоотой байхыг үгүйсгэх аргагүй юм.

Хэдийгээр угсаатны онцлог, тодорхой ялгааг нийгмийн хандлагаар харилцан адилгүй байдлаар тодорхойлон дүгнэн хэвшмэл хэллэг болсон хэдий ч энэхүү харилцан хамаарал адилсалт, ялгааг хорих ял эдлүүлэх практик үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр анхааран үйл ажиллагаандаа тусгалыг нь олж ялтныг хорих ангид хуваарилах, шилжүүлэх, мөн хорих өрөөнд хуваарилах зэрэг ажиллагаанд харгалзан, анхааран авч үзэж байх нь зүйтэй гэж судлаачийн хувьд үзэж байна.



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ХСИС-ийн	Шүүхийн
шийдвэр	гүйцэтгэлийн
сургуулийн	Шүүхийн
шийдвэр	гүйцэтгэлийн
процессийн	эрх зүйн
тэнхмийн	ахлах багш,
дэслэгч	

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААРХИ ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ
БУЙ ЗАРИМ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН
ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор 2002 онд УИХ-аас Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлснээр Үндсэн хуульд тусгалаа олсон хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн баталгааг төр бүрдүүлж, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр олон хуулийг батлан гаргасны нэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Шинээр батлагдсан энэхүү хуулийн үзэл баримтлалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулахаар заасан байна. Энэ хуулийн хүрээнд шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрх ашгийг сэргээж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахтай холбогдсон нийгмийн тодорхой харилцаа зохицуулагдаж байна. Ийнхүү Монгол Улсын үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсөн хэн боловч шүүхэд гомдол, нэхэмжлэл гарган зөрчигдсөн эрхээ сэргээлгэн шийдвэр, магадлал, тогтоол гаргуулдаг. Энэхүү

